

Аудитын код: САГ-2018/209/СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу:

Цахим хуудас: www.audit.mn

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер Г.Гүнжидмаа

Утас: 260512 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Жавхлан
Аудитор Ж.Болормаа

Утас: 261628 Цахим хаяг: javkhlанg@audit.gov.mn
bolormaaj@audit.gov.mn

Улаанбаатар хот

АГУУЛГА

1	Аудитын гэрчилгээ	0
2	Аудитын тайлан	1
2.1	Оршил	1
2.2	Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	2
2.5	Дотоод хяналт	3
2.6	Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	3
2.7	Шилэн дансны мэдээлэл	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	4
2.9.1	Тайлан хоцроосон талаар.....	4
2.9.2	Санхүүгийн тайлангийн талаар	4
2.9.3	Үндсэн хөрөнгийн талаар.....	4
2.9.4	Зардлын тайлагналын талаар	5
2.9.5	Нормативт зардлын талаар.....	5
2.9.6	Санхүүжилтийн зардлын талаар	5
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	5
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	5
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	6
3	МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ.....	7
3.1	НОРМАТИВТ ЗАРДЛЫН ТАЛААР	8
3.2	ЗАРДЛЫН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР	9
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	10
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан	10
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	12
4.3	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	14
4.4	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан	15
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	17



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

2018.02.22 № 06/400
танай _____-ны № _____-т

ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН
ХӨГЖЛИЙН ГАЗРЫН ДАРГА
О.АЛТАНСҮХ ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг захирал О.Алтансүх танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 25-наас 2 дугаар сарын 25-ны хооронд хийж, аудитын тайланг Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Г.Жавхлан, аудитор Ж.Болормаа хариуцаж хэрэгжүүлэв.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны жилийн санхүүгийн тайланг 2018 оны 1 дүгээр сарын 31-ны өдрийн 01/61 дугаартай албан бичгээр Үндэсний аудитын газарт хуулиар тогтоосон хугацаанаас 4 хоног хоцроож ирүүлсэн байна.

2.3 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Тус байгууллага нь гэр бүлийн хөгжил, тогтвортой байдлыг дэмжих, амьдралын чанарыг сайжруулах болон хүүхдийн эрх хөгжил, хамгааллын үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд үзүүлэхэд чиглэсэн бодлогын хэрэгжилтийг хангах, залуучуудын хөгжил, нийгмийн оролцоог дэмжих эрхэм зорилготой ажилладаг.

Дээрх зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхийн тулд Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасны дагуу тус газрын дарга төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны төсвийг Сангийн яамны Төрийн сангаас олгож, хяналт тавьж ажилласан байна.

Тус газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан болно

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар нь холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгүүдийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаж байна. Тухайлбал,

- Гэр бүлийн тухай хууль
- Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль
- Хүүхдийн эрхийн тухай хууль
- Хүүхэд хамгааллын тухай хууль
- Хүүхэд харах үйлчилгээний тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль хууль болон бусад холбогдох хууль УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан холбогдох заавар, журмууд байна.

2.4 АУДИТЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, АРГА ЗҮЙ, ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

Аудитаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлснээс гадна байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа.

Дотоод хяналтын талаарх гол асуудал, дүгнэлтийг энэ тайлангийн 2.5-д үзүүлэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 7 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 42 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим, сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Нягтлан бодох САГ-2018/209/СТА-ТШЗ

бүртгэлийг хөгжүүлэх сангаар хийлгэхээр гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаанд бэлэн болоогүй байна.

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, тайлан гаргах ажиллагааг санхүүгийн “Acolous” програмаар гүйцэтгэдэг байна.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/176 дугаар тушаалаар тус газрын бүтэц, зохион байгуулалт шинэчлэгдэж Хяналт-шинжилгээ, үнэлгээний газар 4 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа бөгөөд дотоод аудитын талаар 2017 онд 5 ажил хийхээр төлөвлөснийг хийж гүйцэтгэсэн байна.

Төлөвлөгөөний дагуу Чингэлтэй дүүргийн болон Завхан, Говь-Алтай, Баян-Өлгий аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын үйл ажиллагаа, хүүхэд харах, хүүхэд хамгаалах зардалд хяналт шалгалт хийж өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг албан бичгээр авсан байна.

Завхан аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргад арга хэмжээ авахуулах санал Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргад хүргүүлсэн боловч хариу ирүүлээгүй байна.

Дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үед “дунд” гэж тооцсон боловч дахин хянахад дотоод хяналт “үр нөлөөтэй” байна.

2.6 Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын зүйл ангиар хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

2017 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг харьцуулан хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Төсөв	Гүйцэтгэл	Зөрүү / сая төгрөг/
Урсгал зардал	7,973.8	7,973.8	-
Бараа, ажил үйлчилгээний зардал	7,953.4	7,785.6	(167.8)
Урсгал шилжүүлэг	20.4	188.2	167.8
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	7,973.8	7,973.8	-

Дээрх хүснэгтээс харахад төсвийн санхүүжилтийг бүрэн авсан бөгөөд төсвийн харилцах дансны үлдэгдэл 167.8 сая төгрөгийг Төрийн санд төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацаанд нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 341.1 сая төгрөгийн орлогын гүйлгээ хийгдсэнээс 216.7 сая төгрөгийг зарцуулж 124.6 сая төгрөгийг Төрийн сангаас авах авлагаар бүртгэсэн байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 5,6,7 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn веб сайтад 3 төрлийн мэдээллийг оруулсан байна.

Цахим хуудсанд төсөв/гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, тендер худалдан авалт, бусад гэсэн мэдээллийн ангиллаар төрийн сан дахь харилцах дансны гүйлгээ, байгууллагын даргын тушаал шийдвэр, гэрээ зэрэг холбогдох мэдээллийг байршуулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 39 эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 42 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны “Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах” гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

Дээрх горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн зарим зөрчилтэй асуудлыг энэ тайлангийн 2.9-д хураангуйлан тэмдэглэв.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Тайлан хоцроосон талаар

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацаанаас 4 хоног хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгах албан шаардлага өгөх

2.9.2 Санхүүгийн тайлангийн талаар

2017 оны жилийн санхүүгийн тайланг авлага, төвлөрүүлэх шилжүүлэг, засгийн газрын хувь оролцоо, өр төлбөрийн тодруулга, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээ зэрэг нийт 175,634.9 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “... санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн зөв мэдээллээр хангах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.3 Үндсэн хөрөнгийн талаар

Тайлант онд ТӨБЗГ-ын холбогдох албан бичгийн дагуу 85,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий автомашин, 22,773.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг данснаас хасаагүй бөгөөд холбогдох хуримтлагдсан элэгдэл 75,713.1 мянган төгрөг тооцоогүй, төсвийн хөрөнгөөр худалдан авсан 2,500.0 сая төгрөгийн олон үйлдэлт хэвлэгчийг зардалд бүртгэсэн зэрэг нийт 185,986.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.9.4 Зардлын тайлагналын талаар

Тайлант хугацаанд нийт 41,750.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж зарцуулсан боловч санхүүгийн үр дүнгийн тайланд 17,666.0 мянган төгрөгийн шатахууны зардал тайлагнаж, 24,084.2 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

2.9.5 Нормативт зардлын талаар

Батлагдсан төсвөөр нормативт зардалд нийт 33,623.0 мянган төгрөг батлагдаж 25,047.4 мянган төгрөг зарцуулсан боловч түр хамгаалах байранд үйлчилгээ авч байгаа нэг хүүхдэд ногдох хоол хүнс, хувцас хэрэглэлд зарцуулах зардлын норматив тодорхойгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Менежментийн захидлаар зөвлөмж өгсөн.

2.9.6 Санхүүжилтийн зардлын талаар

Тайлант хугацаанд орон нутгийн харьяа байгууллагуудад нийт 5,632,882.2 мянган төгрөгийн хүүхэд харах зардал, 231,645.1 мянган төгрөгийн хүүхэд хамгаалах зардал санхүүжүүлснээс 3 аймгийн 506,917.6 мянган төгрөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад залруулсан.

2.10 АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДАЛ

Хүүхэд харах үйлчилгээний санхүүжилт 2018 онд БСШУССайдын төсвийн багцад батлагдсантай холбоотой Эрүүл мэнд нийгмийн бодлогын хүрээлэн ТББ-аар Хүүхэд харах үйлчилгээний хөндлөнгийн хяналт хийлгэсэн боловч хүүхэд харах үйлчилгээний санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт хийгээгүй байна.

2.11 ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АСУУДЛУУД

Тайлант хугацаанд давхардсан тоогоор 883 хүнд нийт 609,096.6 мянган төгрөгийн цалин олгосноос гарт олгосон цалин олговол зохих цалингийн дүнгээс 853.0 мянган төгрөгөөр зөрүүтэй олгогдсон байна.

2.12 АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 893,475.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэнээс 868,538.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 24,937.2 мянган төгрөгийн тайлагналын алдааг залруулах зөвлөмж өгөв.

2.13 ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТ

2016 оны санхүүгийн тайланд УАГ аудит хийж 5 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлтийг 2017 оны 7 сарын 4-ний өдрийн 01/414 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг хянаж үзэхэд орон тооны талаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй, зөвлөмжийн биелэлт 76 хувь байна.

2.14 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитын төлөвлөх ба гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС 320-ын дагуу тодорхойлсон болно.

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын материаллаг байдлыг төлөвлөлтийн шатанд 2017 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтээр авсан учраас гүйцэтгэлийн үед материаллаг байдлыг дахин тооцож үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувь буюу 82,218.5 мянган төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын суурийг өөрчлөхгүй, үр дүнгийн тайлангийн нийт зардлын 70 хувь нь хүүхэд харах болон хүүхэд хамгаалах зардлын орон нутаг дах шилжүүлэг байгаа учраас материаллаг байдлын хувийг 1 хувь болгож бууруулж тооцов.

Гүйцэтгэлийн үе шатанд нэмэлт горим, сорил хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзлээ.

2.15 САНАЛ ДҮГНЭЛТИЙН ХЭЛБЭР, ҮНДЭСЛЭЛ

Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн дүн, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн бодитой, шударга илэрхийлсэн байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим чиглэгдсэн.

Энэ нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн албаны холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан асуудал цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.

3.1 НОРМАТИВТ ЗАРДЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Батлагдсан төсвөөр нормативт зардалд нийт 33,623.0 мянган төгрөг батлагдаж 25,047.4 мянган төгрөг зарцуулсан боловч түр хамгаалах байранд үйлчилгээ авч байгаа нэг хүүхдэд ногдох хоол хүнс, хувцас хэрэглэлд зарцуулах зардлын норматив тодорхойгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3-д “төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн байх” гэсэн төсвийн төсөл боловсруулахад тавигдах шаардлагатай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.2-д “төсвийн захирагч нь төсвийн асуудлаа өөрийн харьяалагдах дээд шатны төсвийн захирагчаар дамжуулан шийдвэрлүүлдэг байх” гэж заасны дагуу нэг хүүхдэд ногдох зардлын нормативыг боловсруулах

Эрсдэлүүд

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, төсвийн гүйцэтгэлд тавих хяналт сулрах

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

3.2 ЗАРДЛЫН ТАЙЛАГНАЛЫН ТАЛААР

Тэргүүлэх ач холбогдол №1

ҮАГ-ын ажиглалт

Тайлант хугацаанд нийт 41,750.2 мянган төгрөгийн шатахууны худалдан авалт хийж зарцуулсан боловч санхүүгийн үр дүнгийн тайланд 17,666.0 мянган төгрөгийн шатахууны зардал тайлагнаж, 24,084.2 мянган төгрөгийн шатахууны зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд бүртгэсэн нь НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.9-д “аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Сангийн Сайдын 2014 оны 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтад дурдсанаар бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд гуравдагч этгээдийн багц үйлчилгээг худалдан авч үйл ажиллагаагаа эрхлэхэд гарах зардлыг бүртгэнэ гэсэн заалтыг баримталж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн холбогдох үзүүлэлт үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх,

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн асуудлын бүртгэлээр танилцуулсан энэхүү алдаа, зөрчлийг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

4 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ**4.1 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

Үзүүлэлт	/төгрөг/	
	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	14,737,632.18	136,256,623.68
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	258,000.00	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	258,000.00	-
Нэмэлт санхүүжилт	258,000.00	-
АВЛАГА	-	124,634,891.00
Байгууллагаас авах авлага	-	124,634,891.00
БАРАА МАТЕРИАЛ	14,479,632.18	11,621,732.68
Түүхий эд материал	-	142,150.00
Эм боох материал	-	53,500.00
Бэлэн бүтээгдэхүүн	-	88,650.00
Хангамжийн материал	14,479,632.18	11,479,582.68
Бичиг хэргийн материал	699,110.00	594,210.00
Аж ахуйн материал	511,700.00	134,995.00
Хүнсний материал	1,498,444.50	-
Бусад хангамжийн материал	11,770,377.68	10,750,377.68
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,111,503,649.06	1,042,485,018.99
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,111,503,649.06	1,042,485,018.99
Биет хөрөнгө	1,111,503,649.06	1,042,485,018.99
Барилга, байгууламж	1,916,728,300.00	1,916,728,300.00
Хуримтлагдсан элэгдэл	(1,079,264,229.96)	(1,111,209,701.64)
Авто тээврийн хэрэгсэл	447,677,209.50	362,677,209.50
Хуримтлагдсан элэгдэл	(306,907,520.72)	(287,425,243.90)
Машин, тоног төхөөрөмж	117,316,496.00	172,250,936.00
Хуримтлагдсан элэгдэл	(81,185,671.59)	(95,139,065.53)
Тавилга, аж ахуйн эд хогшил	106,718,728.00	109,888,008.00
Хуримтлагдсан элэгдэл	(55,318,447.97)	(66,023,664.04)
Зам гүүрийн барилга байгууламж	5,850,000.00	5,850,000.00
Хуримтлагдсан элэгдэл	(5,850,000.00)	(5,850,000.00)
Бусад үндсэн хөрөнгө	109,475,222.00	99,006,896.00
Хуримтлагдсан элэгдэл	(63,736,436.20)	(58,268,655.40)
Програм хангамж	1,135,000.00	1,135,000.00
Хасагдуулга	(1,135,000.00)	(1,135,000.00)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,126,241,281.24	1,178,741,642.67
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	722,800.00	
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	722,800.00	-
Өглөг	722,800.00	-
Ажиллагчидтай холбогдсон өглөг	722,800.00	-
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,125,518,481.24	1,178,741,642.67
Засгийн газрын хувь оролцоо	1,125,518,481.24	511,123,914.11
Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	511,123,914.11	511,123,914.11
Өмч: -Төрийн өмч	511,123,914.11	511,123,914.11
Хуримтлагдсан үр дүн	67,131,979.37	120,355,140.80
Өмнөх үеийн үр дүн	67,131,979.37	67,131,979.37

Тайлант үеийн үр дүн	-	53,223,161.43
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	547,262,587.76	547,262,587.76
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,126,241,281.24	1,178,741,642.67

4.2 Аудит хийгдсэн САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,333,288,599.41	8,382,842,911.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	165,273,999.41	409,007,011.00
Нийтлэг татварын бус орлого	26,884,374.41	409,007,011.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	26,884,374.41	67,908,980.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	26,884,374.41	67,908,980.00
Тусламжийн орлого	138,389,625.00	341,098,031.00
Хандив тусламж /дотоод/	-	637,500.00
Хандив тусламж /гадаад/	138,389,625.00	340,460,531.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,168,014,600.00	7,973,835,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,168,014,600.00	7,973,835,900.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	5,470,455,315.40	8,221,846,163.57
УРСГАЛ ЗАРДАЛ	5,143,913,793.32	8,037,534,770.27
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,143,913,793.32	8,037,534,770.27
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	465,123,500.00	568,404,531.00
Цалин	394,641,200.00	421,770,102.00
Нэмэгдэл цалин	-	66,945,900.00
Унаа хоолны хөнгөлөлт	31,218,000.00	40,816,829.00
Гэрээтийн цалин	39,264,300.00	38,871,700.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,411,775.00	59,229,383.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,443,857.00	59,229,383.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	46,036,723.00	48,771,210.30
Гэрэл цахилгааны зардал	14,370,325.00	16,713,326.30
Түлш, халаалтын зардал	22,713,757.00	27,906,797.00
Цэвэр, бохир усны зардал	2,012,641.00	3,551,087.00
Байрны түрээс	6,940,000.00	600,000.00
Хангамж, бараа материалын зардал	66,942,433.50	46,628,193.40
Бичиг хэргийн материал	13,938,790.00	13,344,580.00
Тээвэр, шатахууны зардал	13,628,420.00	17,666,036.00
Шуудан холбоо интернетийн төлбөр	5,487,614.00	6,104,477.40
Ном, хэвлэлийн зардал	8,097,900.00	-
Хог хаягдал устгах, цэвэрлэх	-	325,000.00
Бага үнэ түргэн элэгдэл зүйлс	25,789,709.50	5,578,100.00
Бараа материал актасны зардал	-	3,610,000.00
Нормативт зардал	40,205,000.00	34,672,552.00
Хоол	40,205,000.00	33,672,552.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	39,752,600.00	12,247,240.00
Урсгал засвар	39,752,600.00	12,247,240.00
Томилолт, зочны зардал	19,551,000.00	12,139,500.00
Дотоод томилолтын зардал	19,123,500.00	12,139,500.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	427,500.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,996,400,882.00	6,553,131,446.94

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,990,277,510.00	6,547,942,948.94
Даатгалын үйлчилгээний төлбөр	994,760.00	988,030.00
Тээврийн хэрэгслийн татвар	488,900.00	509,070.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	932,000.00	168,000.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	3,639,600.00	3,368,200.00
Газрын төлбөр	68,112.00	155,198.00
Бараа үйлчилгээний бусад зардал	420,489,879.82	702,310,713.63
Бараа үйлчилгээний бусад зардал	259,273,695.00	503,215,169.00
Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	27,125,336.00	65,728,105.00
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	134,090,848.82	133,367,439.63
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	326,541,522.08	184,311,393.30
Бусад урсгал шилжүүлэг	120,528,908.00	16,524,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	97,513,900.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,238,008.00	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,777,000.00	16,524,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	206,012,614.08	167,787,393.30
Төвлөрүүлэх шилжүүлэг	206,012,614.08	167,787,393.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(137,166,715.99)	160,996,747.43
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	1,214,565.93	107,773,586.00
Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	1,214,565.93	107,773,586.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	(1,214,565.93)	(107,773,586.00)
НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(138,381,281.92)	53,223,161.43

4.3 Аудит хийгдсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2016 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	67,131,979.37	1,125,518,481.24
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	67,131,979.37	1,125,518,481.24
Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			53,223,161.43	53,223,161.43
2017 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	511,123,914.11	547,262,587.76	120,355,140.80	1,178,741,642.67

4.4 Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан

	/төгрөг/	
Үзүүлэлт	2016 оны 12 сарын 31	2017 оны 12 сарын 31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,315,655,049.08	8,387,777,780.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	138,389,625.00	413,941,880.00
Нийтлэг татварын бус орлого	-	72,843,849.00
Бусад орлого	-	72,843,849.00
Тусламжийн орлого	138,389,625.00	341,098,031.00
Хандив тусламж /дотоод/	-	637,500.00
Хандив тусламж /гадаад/	138,389,625.00	340,460,531.00
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,177,265,424.08	7,973,835,900.00
Төсвийн захирагчдаас	9,250,824.08	7,973,835,900.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,168,014,600.00	7,973,835,900.00
Төвлөрүүлэх шилжүүлэг	9,250,824.08	-
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	5,315,397,849.08	8,385,535,780.00
УРСГАЛ ЗАРДАЛ	5,315,397,849.08	8,385,535,780.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,988,856,327.00	8,072,713,495.70
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	464,658,700.00	568,404,531.00
Үндсэн цалин	394,176,400.00	421,770,102.00
Нэмэгдэл	-	66,945,900.00
Унаа хоолны хөнгөлөлт	31,218,000.00	40,816,829.00
Гэрээт ажлын хөлс	39,264,300.00	38,871,700.00
Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	50,111,100.00	59,229,383.00
Тэтгэврийн даатгалын шимтгэл	31,888,882.00	59,229,383.00
Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	46,836,723.00	48,771,210.30
Гэрэл цахилгааны зардал	14,370,325.00	16,713,326.30
Түлш, халаалтын зардал	22,713,757.00	27,906,797.00
Цэвэр, бохир усны зардал	2,012,641.00	3,551,087.00
Байрны түрээс	7,740,000.00	600,000.00
Хангамж, бараа материалын зардал	40,175,491.00	44,641,533.40
Бичиг хэрэг	10,167,000.00	10,443,950.00
Тээвэр, шатахуун	13,628,420.00	20,459,706.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,487,614.00	6,155,977.40
Ном, хэвлэл	8,097,900.00	-
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	325,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,794,557.00	7,256,900.00
Нормативт зардал	40,205,000.00	43,466,422.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	566,470.00
Хоол, хүнс	40,205,000.00	33,672,552.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	9,227,400.00
Эд хогшил, урсгал засварын зардал	39,752,600.00	12,581,240.00
Багаж техник хэрэгсэл	-	334,000.00
Урсгал засвар	39,752,600.00	12,247,240.00

Томилолт, зочны зардал	19,551,000.00	12,064,000.00
Дотоод албан томилолт	19,123,500.00	12,064,000.00
Зочин төлөөлөгч хүлээн авах	427,500.00	-
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,996,400,882.00	6,714,611,902.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,990,277,510.00	6,709,188,404.00
Даатгалын үйлчилгээ	994,760.00	988,030.00
Тээврийн хэрэгслийн татвар	488,900.00	509,070.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	932,000.00	168,000.00
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,639,600.00	3,603,200.00
Газрын төлбөр	68,112.00	155,198.00
Бараа үйлчилгээний бусад зардал	291,164,831.00	568,943,274.00
Бараа үйлчилгээний бусад зардал	264,039,495.00	503,215,169.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлаг хийх	27,125,336.00	65,728,105.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	326,541,522.08	312,822,284.30
Бусад урсгал шилжүүлэг	120,528,908.00	20,400,000.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	97,513,900.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	16,238,008.00	-
Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	6,777,000.00	20,400,000.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	206,012,614.08	292,422,284.30
Төвлөрүүлэх шилжүүлэг	206,012,614.08	292,422,284.30
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	257,200.00	2,242,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	2,500,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН		2,500,000.00
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,500,000.00
Тоног төхөөрөмж		2,500,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		(2,500,000.00)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	257,200.00	(258,000.00)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	258,000.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	258,000.00	-

4.5 Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

Үзүүлэлт	Тайлант 2017 он		Зөрүү
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,973,835,900.00	7,973,835,900.00	-
УРСГАЛ ЗАРДАЛ	7,953,435,900.00	7,973,835,900.00	20,400,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,953,435,900.00	7,785,648,506.70	(167,787,393.30)
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	569,023,100.00	567,124,531.00	(1,898,569.00)
Үндсэн цалин	422,149,600.00	420,490,102.00	(1,659,498.00)
Нэмэгдэл	66,945,900.00	66,945,900.00	-
Унаа хоолны хөнгөлөлт	41,055,900.00	40,816,829.00	(239,071.00)
Гэрээт ажлын хөлс	38,871,700.00	38,871,700.00	-
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	62,589,900.00	59,229,383.00	(3,360,517.00)
Тэтгэврийн даатгал	45,616,200.00	43,118,991.00	(2,497,209.00)
Тэтгэмжийн даатгал	4,243,400.00	3,968,369.00	(275,031.00)
ҮОМШӨ-ний даатгал	3,394,800.00	3,257,616.00	(137,184.00)
Ажилгүйдлийн даатгал	848,600.00	829,211.00	(19,389.00)
Эрүүл мэндийн даатгал	8,486,900.00	8,055,196.00	(431,704.00)
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,603,600.00	48,171,210.30	(40,432,389.70)
Гэрэл, цахилгаан	27,208,400.00	16,713,326.30	(10,495,073.70)
Түлш, халаалт	51,425,400.00	27,906,797.00	(23,518,603.00)
Цэвэр, бохир ус	9,969,800.00	3,551,087.00	(6,418,713.00)
Хангамж, бараа материалын зардал	24,931,700.00	24,909,783.40	(21,916.60)
Бичиг хэрэг	6,504,300.00	6,954,340.00	450,040.00
Тээвэр, шатахуун	4,680,700.00	4,877,566.00	196,866.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,982,300.00	5,495,977.40	513,677.40
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	266,000.00	325,000.00	59,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	8,498,400.00	7,256,900.00	(1,241,500.00)
Нормативт зардал	33,623,000.00	25,047,422.00	(8,575,578.00)
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,319,000.00	566,470.00	(752,530.00)
Хоол, хүнс	22,432,000.00	15,253,552.00	(7,178,448.00)
Нормын хувцас, зөөлөн эдлэл	9,872,000.00	9,227,400.00	(644,600.00)
Эд хогшил, урсгал засварын зардал	12,581,300.00	12,581,240.00	(60.00)
Багаж, техник, хэрэгсэл	334,000.00	334,000.00	-
Урсгал засвар	12,247,300.00	12,247,240.00	(60.00)
Томилот, зочны зардал	210,000.00	75,500.00	(134,500.00)
Дотоод албан томилот	210,000.00	75,500.00	(134,500.00)
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,590,895,300.00	6,476,186,484.00	(114,708,816.00)

Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,579,733,000.00	6,470,762,986.00	(108,970,014.00)
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	4,599,000.00	-	(4,599,000.00)
Даатгалын үйлчилгээ	990,000.00	988,030.00	(1,970.00)
Тээврийн хэрэгслийн татвар	782,100.00	509,070.00	(273,030.00)
Тээврийн хэрэгслийн оношлогоо	990,000.00	168,000.00	(822,000.00)
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,603,200.00	3,603,200.00	-
Газрын төлбөр	198,000.00	155,198.00	(42,802.00)
Бараа үйлчилгээний бусад зардал	570,978,000.00	569,822,953.00	(1,155,047.00)
Бараа үйлчилгээний бусад зардал	504,207,000.00	503,269,848.00	(937,152.00)
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	66,771,000.00	66,553,105.00	(217,895.00)
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,400,000.00	188,187,393.30	167,787,393.30
Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	167,787,393.30	167,787,393.30
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	167,787,393.30	167,787,393.30
Бусад урсгал шилжүүлэг	20,400,000.00	20,400,000.00	-
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,400,000.00	20,400,000.00	-
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,500,000.00	2,500,000.00
Дотоод эх үүсвэрээр	-	2,500,000.00	2,500,000.00
Тоног төхөөрөмж	-	2,500,000.00	2,500,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,973,835,900.00	7,973,835,900.00	-
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,973,835,900.00	7,973,835,900.00	-
Улсын төсвөөс санхүүжих	7,973,835,900.00	7,973,835,900.00	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	54.00	54.00	-
Удирдах ажилтан	2.00	2.00	-
Гүйцэтгэх ажилтан	41.00	41.00	-
Үйлчлэх ажилтан	11.00	11.00	-
Гэрээт ажилтан	-	-	-